СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2023/95-НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.open.audit.mn

Сүхбаатар сум

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Б.Ундаръяа

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan @gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| **УСНББОУС** | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| **АДБОУС** | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| **ТӨБЗГ** | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| **БШУС** | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| **БШУГ** | Боловсрол, шинжлэх ухааны газар |
| **ЗГ** | Засгийн газар |
| **БЕГ** | Боловсролын ерөнхий газар |
| **ЗДТГ** | Засаг даргын Тамгын газар |
| **ХНХС** | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд |
| **НДШ** | Нийгмийн даатгалын шимтгэл |
| **СӨБ** | Сургуулийн өмнөх боловсрол |
| **БШУЯ** | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| **БҮХТ** | Боловсролын үнэлгээний хөгжлийн төв |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан........ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 10
3.Санхүүгийн тайлангийн тодруулга........ 11
3.1.Байгууллага түүний үйл ажиллагаа........ 11
3.2. Байгууллагын гадаад дотоод орчин........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........ 12
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.. 13
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........ 14
4.Аудитын тайлан........15
4.1 Ерөнхий зүйл........ 15
4.2 Материаллаг байдал........ 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт........ 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .... .16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ 17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал........ 18
5. Аудитын илрүүлэлт........19
5.1 Албан шаардлага........ 19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл........19

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

АЛТАНБУЛАГ СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.БОЛОРМАА ТАНАА

2023.02.25 № СТА-2023/95-НА-СТА-ТИЗ

танай ________-ны № ________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 98.6 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 2,554.3 мянган төгрөгөөр, хоолыг зардлыг 4,581.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 1.4 хувиар хэмнэгдсэн байна.

018020271

**Аудитын гол асуудал**

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 75.4 хувийг цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 9.7 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **25,583,261.02** | **36,848,602.02** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **0.00** | **7,135,249.00** |
| **31100** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | **0.00** | **0.00** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **0.00** | **7,135,249.00** |
| **31210** | **Төгрөг** | **0.00** | **7,135,249.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 7,135,249.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **25,583,261.02** | **29,713,353.02** |
| **35400** | **Хангамжийн материал** | **25,583,261.02** | **29,713,353.02** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.00 | 150,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,583,261.02 | 27,887,661.02 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 68,568.00 |
| 35460 | Хүнсний материал | 0.00 | 1,607,124.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **831,552,691.86** | **813,019,867.45** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **831,552,691.86** | **813,019,867.45** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **784,042,158.34** | **765,784,333.85** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 718,906,860.00 | 718,906,860.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -35,945,343 | -47,927,124.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 29,207,608.70 | 32,967,608.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -5,268,847 | -13,073,975.04 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,371,275.94 | 21,691,175.94 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,571,101 | -10,788,946.75 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 67,492,632.00 | 67,492,632.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -8,077,523 | -10,770,030.24 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 11,146,698.00 | 11,146,698.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,297,017 | -4,937,478.76 |
| 39217 | Ном | 1,076,914.00 | 1,076,914.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **47,510,533.52** | **47,235,533.60** |
| 39301 | Програм хангамж | 1,625,000.00 | 1,625,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -741,666.48 | -1,016,666.40 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 46,627,200.00 | 46,627,200.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **857,135,952.88** | **849,868,469.47** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **857,135,952.88** | **849,868,469.47** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **857,135,952.88** | **849,868,469.47** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 106,812,733.82 | 106,812,733.82 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 0.00 | 106,812,733.82 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **479,425,173.32** | **472,157,689.91** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 490,555,482.22 | -377,710,779.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -11,130,308.90 | 849,868,469.47 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 270,898,045.74 | 270,898,045.74 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **857,135,952.88** | **849,868,469.47** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **473,109,621.59** | **1,389,413,822.88** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **0** | **0.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,837,315.59** | **860,559,452.88** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **19,837,315.59** | **860,559,452.88** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 19,291,169.59 | 834,652,691.86 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 546,146.00 | 25,906,761.02 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **453,272,306.00** | **528,854,370.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **401,380,500.00** | **451,336,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 401,380,500.00 | 451,336,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,089,144.00** | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,089,144.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **50,802,662.00** | **77,518,170.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 50,802,662.00 | 77,518,170.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **469,447,125.12** | **539,545,353.41** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **469,447,125.12** | **539,545,353.41** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **446,345,640.97** | **539,545,353.41** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **312,935,729.12** | **350,017,613.00** |
| 210101 | Үндсэн цалин | 229,331,624.12 | 247,024,788.00 |
| 210102 | Нэмэгдэл | 63,196,905.00 | 82,200,092.00 |
| 210104 | Урамшуулал | 20,407,200.00 | 20,792,733.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,106,470.73** | **43,658,633.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,622,222.00 | 29,806,115.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,226,332.00 | 3,463,057.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,468,481.00 | 2,770,548.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 632,971.00 | 692,513.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,156,464.73 | 6,926,399.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,179,762.00** | **50,671,145.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,033,144.00 | 4,537,927.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,597,058.00 | 35,596,888.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,549,560.00 | 10,536,330.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,063,407.08** | **0.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 281,500.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 226,400.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 735,000.00 | 0.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,045,191.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 432,500.00 | 0.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,342,816.08 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **11,455,010.00** | **42,334,706.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 59,600.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,395,410.00 | 42,334,706.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,088,900.00** | **1,946,100.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,088,900.00 | 1,946,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **84,000.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 84,000.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **824,650.00** | **962,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,650.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 810,000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 962,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **21,607,712.04** | **49,955,156.41** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0 | 18,738,932.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,373,500.00 | 4,603,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 20,234,212.04 | 26,612,724.41 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23,101,484.15** | **0.00** |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **23,101,484.15** | **0.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,101,484.15 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **3,662,496.50** | **849,868,469.47** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **396,635.78** | **0.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 396,635.78 | 0.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **3,262,860.70** | **849,868,469.47** |
| VI-I | Засгийн газрын хувь оролцоо | 0 | 0.00 |
| VI-II | Хяналтын бус хувь оролцоо | 0 | 0.00 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **453,272,306.00** | **528,854,370.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **0** | **0.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **453,272,306.00** | **528,854,370.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **401,380,500.00** | **451,336,200.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 401,380,500.00 | 0.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,089,144.00** | **0.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,089,144.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **50,802,662.00** | **77,518,170.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 50,802,662.00 | 77,518,170.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **451,072,306.00** | **516,739,221.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **451,072,306.00** | **516,739,221.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **427,970,821.85** | **506,164,721.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **312,935,729.12** | **350,417,613.00** |
| 210101 | Үндсэн цалин | 229,331,624.12 | 247,424,788.00 |
| 210102 | Нэмэгдэл | 63,196,905.00 | 82,200,092.00 |
| 210104 | Урамшуулал | 20,407,200.00 | 20,792,733.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,106,470.73** | **43,258,633.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,622,222.00 | 29,406,115.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,226,332.00 | 3,463,057.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,468,481.00 | 2,770,548.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 632,971.00 | 692,513.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,156,464.73 | 6,926,399.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,179,762.00** | **50,671,145.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,033,144.00 | 4,537,927.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,597,058.00 | 35,596,888.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,549,560.00 | 10,536,330.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,617,400.00** | **0.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 281,500.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 226,400.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 735,000.00 | 0.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 0 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 940,600.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 433,900.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **16,580,010.00** | **43,941,830.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 59,600.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,395,410.00 | 43,941,830.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,125,000.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,088,900.00** | **1,946,100.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,088,900.00 | 1,946,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **84,000.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 84,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,005,050.00** | **962,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 195,050.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 810,000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 962,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,373,500.00** | **14,967,400.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,373,500.00 | 10,467,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 4,500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23,101,484.15** | **10,574,500.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **10,574,500.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 10,574,500.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.00** | **0.00** |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | **23,101,484.15** | 0.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,101,484.15 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **2,200,000.00** | **12,115,149.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **2,200,000.00** | **4,979,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,200,000.00** | **4,979,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **2,200,000.00** | **4,979,900.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,200,000.00 | 4,979,900.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-2,200,000.00** | **-4,979,900.00** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **0.00** | **0.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0.00** | **7,135,249.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 7,135,249.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **106,812,733.82** | **256,501,876.15** | **465,029,003.73** | **828,343,613.70** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **106,812,733.82** | **256,501,876.15** | **490,555,482.22** | **853,870,092.19** |
| **7** | **Өмчид гарсан өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | 509,917,801.95 | 509,917,801.95 |
| **10** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **106,812,733.82** | **256,501,876.15** | **465,029,003.73** | **828,343,613.70** |
| **11** | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 106,812,733.82 | 270,898,045.74 | -377,710,779.56 | 0.00 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **106,812,733.82** | **270,898,045.74** | **-377,710,779.56** | **0.00** |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 849,868,469.47 | 849,868,469.47 |
| **20** | **2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **106,812,733.82** | **270,898,045.74** | **472,157,689.91** | **849,868,469.47** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **528,854,370.00** | **521,719,121.00** | **7,135,249.00** | **98.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **528,854,370.00** | **521,719,121.00** | **7,135,249.00** | **98.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **506,164,721.00** | **506,164,721.00** | **0.00** | |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **352,154,242.00** | **350,417,613.00** | **1,736,629.00** | **99.51** |
| 210101 | Үндсэн цалин | 249,161,417.00 | 247,424,788.00 | 1,736,629.00 | 99.30 |
| 210102 | Нэмэгдэл | 82,200,092.00 | 82,200,092.00 | **0.00** | |
| 210104 | Урамшуулал | 20,792,733.00 | 20,792,733.00 | **0.00** | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **44,076,283.00** | **43,258,633.00** | **817,650.00** | **98.14** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,962,118.00 | 29,406,115.00 | 556,003.00 | 98.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,528,491.25 | 3,463,057.25 | 65,434.00 | 98.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,822,833.20 | 2,770,548.20 | 52,285.00 | 98.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 705,658.05 | 692,513.05 | 13,145.00 | 98.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,057,182.50 | 6,926,399.50 | 130,783.00 | 98.15 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **50,671,145.00** | **50,671,145.00** | **0.00** | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,537,927.00 | 4,537,927.00 | **0.00** | |
| 210302 | Түлш, халаалт | 35,596,888.00 | 35,596,888.00 | **0.00** | |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,536,330.00 | 10,536,330.00 | **0.00** | |
| **2105** | **Нормативт зардал** | **48,522,800.00** | **43,941,830.00** | **4,580,970.00** | **90.56** |
| 210502 | Хоол, хүнс | 48,522,800.00 | 43,941,830.00 | 4,580,970.00 | 90.56 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,946,100.00** | **1,946,100.00** | **0.00** | |
| 210604 | Урсгал засвар | 1,946,100.00 | 1,946,100.00 | **0.00** | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **962,000.00** | **962,000.00** | **0.00** | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 962,000.00 | 962,000.00 | **0.00** | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **19,947,300.00** | **19,947,300.00** | **0.00** | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,447,300.00 | 15,447,300.00 | **0.00** | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,500,000.00 | 4,500,000.00 | **0.00** | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,574,500.00** | **10,574,500.00** | **0.00** | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **10,574,500.00** | **10,574,500.00** | **0.00** | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,574,500.00 | 10,574,500.00 | **0.00** | |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **528,854,370.00** | **528,854,370.00** | **0.00** | |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **451,336,200.00** | **451,336,200.00** | **0.00** | |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 451,336,200.00 | 451,336,200.00 | **0.00** | |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **77,518,170.00** | **77,518,170.00** | **0.00** | |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 77,518,170.00 | 77,518,170.00 | **0.00** | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 7,135,249.00 | **-7,135,249.00** | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **0.00** | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | **0.00** | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **26.00** | **26.00** | **0.00** | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | **0.00** | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9.00 | 9.00 | **0.00** | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 | **0.00** | |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | **115.00** | **115.00** | **0.00** | |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 115.00 | 115.00 | **0.00** | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **0.00** | **0.00** | **0.00** | |
| 650004 | СЕБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 15.00 | 15.00 | **0.00** | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 11.00 | 11.00 | **0.00** | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг нь *"Хүүхэд нэг бүрийн танин мэдэх хэрэгцээ сонирхолд нийцсэн ээлтэй орчин бүрдүүлж, тэдний бие даасан байдлыг дэмжих, тоглох явцдаа хамтдаа хөгжинө"* гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны зорилтуудаа дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- СӨБ-ийн төрийн бодлого хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, хамрах сургалтуудыг нэмэгдүүлж ажиллана. Энэ зорилтын хүрээнд 19 ажлыг төлөвлөн зохион байгуулж, 138 ажлыг хийж гүйцэтгэсэн байна.
- СӨБ-ийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургалтын чанарыг ахиулж, багшийн хөгжлийг дэмжин ажиллана. Энэ зорилтын хүрээнд 15 ажлыг төлөвлөн зохион байгуулж ажилласан байна.
- Хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшлийн олон талт арга хэмжээг зохион байгуулж хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллах. Энэ зорилтын хүрээнд 6 ажлыг төлөвлөн зохион байгуулж, 46 ажлыг хийж гүйцэтгэсэн байна.
- Хүүхдийн сурч хөгжих эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн ажиллана.
- Эрүүл аюулгүй хоол хүнс, орчин нөхцөлийг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй, хэрэгжүүлнэ.
- Эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,

- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай" журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батдагдсан "Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай " тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох" тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан "Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам" хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,264.4 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 7,135.2 | 7,135.2 |
| Авлага | | | - |
| Бараа материал | 25,583.2 | 29,713.4 | 4,130.2 |
| Үндсэн хөрөнгө | 831,552.7 | 813,019.9 | (18,532.8) |
| Нийт хөрөнгө | **857,135.9** | **849,868.5** | **(7,264.4)** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 857,135.9 | 849,868.5 | **(7,264.4)** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **857,135.9** | **849,868.5** | **(7,264.4)** |

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 7,135.2 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт *“Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх*

*аргачлал"*-ын 8.7-д *"Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ"* гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,130.2 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-наас 103.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 220.0 мянган төгрөгийн кварцын гэрэл үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан, төсвийн хөрөнгөөр 55,045.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон үйл ажиллагаанд 51,238.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /*анхны өртгөөр*/ 8,079.9 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-наас 3,100.0 мянган төгрөгийн 2-р хоолны тогоо үнэ төлбөргүй хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 4,979.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 849,868.5 мянган төгрөг болж 7,264.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 592,381.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 90,833.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 683,214.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-н зардлыг 84,932.9 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 31,264.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 38,162.8 мянган төгрөгөөр буюу нийт төсвийг 154,360.2 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 451,336.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 77,518.2 мянган төгрөг нийт 528,854.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 451,336.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 77,518.2 мянган төгрөг, нийт 528,854.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 521,719.1 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-н зардлыг 2,554.3 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 4,581.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр | Д/д | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71801 Сургуулийн өмнөх боловсрол | 1 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 1,300.00 | 1,300.00 | - | 100.00 |
| | | 2 | 81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 48,522.80 | 43,941.80 | 4,581.00 | 90.56 |
| | | 3 | 81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 1,117.40 | 1,117.40 | - | 100.00 |
| | | 4 | 81823-Боловсролын байгууллагын багш | 1,300.00 | 1,300.00 | - | 100.00 |
| | | 5 | 81834-Боловсролын стандарт сургалт | 327,128.40 | 324,574.10 | 2,554.30 | 99.22 |
| | | 6 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 71,967.60 | 71,967.60 | - | 100.00 |
| | | 7 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 52,617.20 | 52,617.20 | - | 100.00 |
| | | 8 | 80112-Нийтлэг үйлчилгээ | 24,900.90 | 24,900.90 | - | 100.00 |
| **Нийт** | | | | **528,854.30** | **521,719.00** | **7,135.30** | **98.65** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансанд орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Ундаръяа, аудиторын туслах Б.Цэвэлмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бэйкер Тилли Далайван аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 469,447.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,694.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Тайлант онд хоолны зардал, цалин, ажил олгогчоос төлөх НДШ-н зардлаас нийт 7,135.2 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

"Бэйкер Тилли Далайван аудит" ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 02-ны өдрийн 48 дугаар албан бичгээр "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин хөлстэй холбоотой 413.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 акт тогтоож, төлбөрийн цахим баримттай холбоотой 11,395.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснөөс, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулалгүй худалдан авалт хийсэн зөрчлийг давтан гаргасан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 431.3 | 1 | 413.3 | **100.0** |
| Зөвлөмж | 2 | 11,395.4 | 2 | 8,758.0 | **76.0** |
| **Нийт дүн** | **6** | **11,826.7** | **2** | **9,171.3** | **77.5** |

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95

дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх ”Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу ***албан шаардлага*** хүргүүлэхээр шийдвэрлэв.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны *“Чиглэл хүргүүлэх тухай”* албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан *“Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан”* гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого /120010/ ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **2,637.4** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй **2,637.4** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэлт:* МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*", 4.2.1.10: "*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1.Худалдан авалтыг | 1 | 2,637.4 | | | 1 | 2,637.4 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| цахим баримтаар баталгаажуулаагүй | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | 1 | 2,637.4 | | | 1 | 2,637.4 | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээлэл хоцроосон | | - | | | | - | | |
| Огт мэдээлэлгүй | | | | | | | | |
| Дүн | | | | | | - | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |